



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/163-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум</p> <p>2022 он</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас:70363040; Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас:70363036; Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Утас: 77270808; Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СА-2022/163-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

САНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙБАДРАХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,387,917.37	74,801,020.75
35	БАРАА МАТЕРИАЛ	48,387,917.37	74,801,020.75
351	Түүхий эд материал	2,376,737.78	2,230,137.78
3511	Тусгай зориулалттай материал	2,148,337.78	2,230,137.78
3513	Эм боох материал	228,400.00	0,00
354	Хангамжийн материал	46,011,179.59	72,570,882.97
3541	Бичиг хэргийн материал	459,000.00	669,000.00
3542	Аж ахуйн материал	2,559,149.91	2,169,149.91
3545	Барилгын засварын материал	3,251,850.00	3,643,350.00
3546	Хүнсний материал	3,146,695.00	9,135,445.00
3547	Бусад хангамжийн материал	36,594,484.68	56,953,938.06
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,995,299,437.52	2,919,371,917.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,995,299,437.52	2,919,371,917.30
392	Биет хөрөнгө	2,955,820,937.49	2,880,143,417.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,030,247,484.00	3,030,247,484.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-192,611,704.07	-246,765,828.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,562,500.00	29,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,562,500.00	-29,562,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	214,722,578.50	179,373,194.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	-173,653,014.69	-138,020,734.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	145,191,732.68	97,694,409.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	-93,619,019.18	-68,302,963.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,779,042.05	11,761,159.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,378,882.93	-3,533,180.47
39217	Ном	16,142,721.13	17,689,876.80
393	Биет бус хөрөнгө	39,478,500.03	39,228,500.07
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-437,499.97	-687,499.93
39303	Бусад биет бус хөрөнгө	38,416,000.00	38,416,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,043,687,354.89	2,994,172,938.05
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,043,687,354.89	2,994,172,938.05
51	Засгийн газрын хувь оролцоо	3,043,687,354.89	2,994,172,938.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,052,161,520.45	1,052,161,520.45
51101	Өмч: - төрийн	1,052,161,520.45	1,052,161,520.45
512	Хуримтлагдсан үр дүн	-749,777,022.29	-799,291,439.13
5121	Өмнөх үеийн үр дүн	-749,777,022.29	-749,777,022.29
5122	Тайлант үеийн үр дүн		-49,514,416.84
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,741,302,856.73	2,741,302,856.73
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,043,687,354.89	2,994,172,938.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,155,918,620.11	822,662,443.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,811,271.91	21,829,895.41
120	Нийтлэг татварын бус орлого	395,476,271.91	21,829,895.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	395,476,271.91	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	395,476,271.91	0.00
120005	Түрээсийн орлого	0.00	1,628,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	2,410,792.03
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	17,791,003.38
122	Тусламжийн орлого	5,335,000.00	0.00
122002	Хандив тусламж /гадаад/	5,335,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,107,348.20	800,832,548.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	647,890,200.00	800,183,548.28
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	107,217,148.20	135,150,348.28
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	647,890,200.00	665,033,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	649,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	649,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	805,188,362.68	862,656,980.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	805,188,362.68	862,656,980.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	758,200,337.19	824,886,528.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	483,555,990.65	500,921,734.08
210101	Үндсэн цалин	318,532,459.30	359,101,401.32
210102	Нэмэгдэл	133,123,471.45	112,923,982.97
210104	Урамшуулал	31,900,059.90	28,896,349.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,748,597.86	65,282,268.49
210201	Тэтгэврийн даатгал	41,481,878.02	45,502,281.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,846,957.79	5,008,835.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,867,775.59	3,976,837.44
210204	Ажилгүйдлийн даатгал	956,375.09	979,687.61
210205	Эрүүл мэндийн даатгал	9,595,611.37	9,814,626.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,217,148.20	127,150,423.28
210301	Гэрэл, цахилгаан	8,839,817.20	10,218,566.40
210302	Түлш, халаалт	93,959,731.00	114,514,257.88
210303	Цэвэр, бохир ус	2,417,600.00	2,417,599.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,340,076.00	10,253,316.00
210401	Бичиг хэрэг	1,278,010.00	842,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,515,406.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	204,900.00	1,456,200.00
210404	Ном, хэвлэл	197,000.00	1,753,430.00

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,275,000.00	2,682,456.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	869,760.00	2,718,430.00
2105	Нормативт зардал	13,758,935.00	21,093,010.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	392,700.00	2,533,950.00
210502	Хоол, хүнс	12,703,535.00	18,559,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	662,700.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,699,100.00	12,218,525.00
210604	Урсгал засвар	8,699,100.00	12,218,525.00
2107	Томилолт, зочны зардал	147,500.00	161,200.00
210702	Дотоод албан томилолт	147,500.00	161,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,132,800.00	1,472,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,800.00	608,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	864,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,600,189.48	86,333,651.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,045,400.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	354,990.00	4,915,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,199,799.48	81,417,831.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,988,025.49	37,770,451.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,436,350.00	18,594,840.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,636,350.00	18,094,840.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,551,675.49	19,175,611.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,551,675.49	19,175,611.43
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	350,730,257.43	-39,994,536.48
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	9,519,880.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	9,519,880.36
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-9,519,880.36
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	350,730,257.43	-49,514,416.84

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	933,777,797.63	2,859,686,579.55
Тайлант үеийн үр дүн			350,730,257.43	350,730,257.43
2020 оны 12-р сарын 31-	1,052,161,520.45	2,741,302,856.73	749,777,022.29	3,043,687,354.89

нээрх үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн			-49,514,416.84	-49,514,416.84
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	799,291,439.13	2,994,172,938.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	755,107,348.20	802,460,648.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,628,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,628,100.00
120005	Түрээсийн орлого	0.00	1,628,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,107,348.20	800,832,548.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	755,107,348.20	800,183,548.28
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	107,217,148.20	135,150,348.28
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	647,890,200.00	665,033,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	649,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	649,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	738,507,348.20	789,861,248.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	738,507,348.20	789,861,248.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	691,221,872.71	749,791,366.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	483,595,891.13	500,921,734.08
210101	Үндсэн цалин	289,315,764.62	359,101,401.32
210102	Нэмэгдэл	162,380,066.61	112,923,982.97
210104	Урамшуулал	31,900,059.90	28,896,349.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,708,697.38	65,282,268.49
210201	Тэтгэврийн даатгал	41,446,177.91	45,502,281.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,842,757.78	5,008,835.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,867,775.50	3,976,837.44
210204	Ажилгүйдлийн даатгал	956,374.92	979,687.61
210205	Эрүүл мэндийн даатгал	9,595,611.27	9,814,626.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,217,148.20	127,150,423.28
210301	Гэрэл, цахилгаан	8,839,817.20	10,218,566.40
210302	Түлш, халаалт	93,959,731.00	114,514,257.88
210303	Цэвэр, бохир ус	2,417,600.00	2,417,599.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,027,106.00	10,543,886.00
210401	Бичиг хэрэг	218,200.00	842,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	204,900.00	1,456,200.00
210404	Ном, хэвлэл	197,000.00	2,044,000.00

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,467,006.00	2,682,456.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,440,000.00	2,718,430.00
2105	Нормативт зардал	21,778,630.00	28,562,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	152,000.00	2,305,550.00
210502	Хоол, хүнс	11,364,180.00	22,327,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,262,450.00	3,930,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,749,100.00	12,185,725.00
210604	Урсгал засвар	8,749,100.00	12,185,725.00
2107	Томилолт, зочны зардал	147,500.00	161,200.00
210702	Дотоод албан томилолт	147,500.00	161,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,382,800.00	1,472,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,800.00	608,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,615,000.00	3,510,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,232,300.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,382,700.00	3,510,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,285,475.49	40,069,881.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,733,800.00	20,894,270.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,933,800.00	20,394,270.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,551,675.49	19,175,611.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,551,675.49	19,175,611.43
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,600,000.00	12,599,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,850,000.00	12,599,400.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	17,850,000.00	12,599,400.00
	Дотоод эх үүсвэрээр	17,850,000.00	12,599,400.00
222001	Тоног төхөөрөмж		12,599,400.00
223001	Бусад хөрөнгө	17,850,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-17,850,000.00	-12,599,400.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-1,250,000.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	871,230,900.00	781,007,936.85	90,222,963.15

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	871,230,900.00	781,007,936.85	90,222,963.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	849,437,600.00	760,113,666.85	89,323,933.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,010,700.00	500,921,734.08	15,088,965.92
210101	Үндсэн цалин	375,159,400.00	359,101,401.32	16,057,998.68
210102	Нэмэгдэл	112,360,400.00	112,923,982.97	-563,582.97
210104	Урамшуулал	28,490,900.00	28,896,349.79	-405,449.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,626,100.00	65,282,268.49	2,343,831.51
210201	Тэтгэврийн даатгал	46,985,600.00	45,502,281.76	1,483,318.24
210202	Тэтгэмжийн даатгал	5,160,100.00	5,008,835.22	151,264.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,128,100.00	3,976,837.44	151,262.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,032,000.00	979,687.61	52,312.39
210205	Эрүүл мэндийн даатгал	10,320,300.00	9,814,626.46	505,673.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,197,700.00	127,150,423.28	71,047,276.72
210301	Гэрэл, цахилгаан	10,763,600.00	10,218,566.40	545,033.60
210302	Түлш, халаалт	185,016,500.00	114,514,257.88	70,502,242.12
210303	Цэвэр, бохир ус	2,417,600.00	2,417,599.00	1.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,490,000.00	8,266,786.00	223,214.00
210401	Бичиг хэрэг	666,800.00	666,800.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,456,200.00	1,456,200.00	0.00
210404	Ном, хэвлэл	415,900.00	415,900.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,204,200.00	2,209,456.00	-5,256.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,946,900.00	2,718,430.00	228,470.00
2105	Нормативт зардал	28,574,000.00	28,562,830.00	11,170.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,316,700.00	2,305,550.00	11,150.00
210502	Хоол, хүнс	22,327,100.00	22,327,080.00	20.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,930,200.00	3,930,200.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,818,600.00	24,785,125.00	33,475.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,600,000.00	12,566,600.00	33,400.00
210604	Урсгал засвар	12,218,600.00	12,218,525.00	75.00
2107	Томилолт, зочны зардал	161,200.00	161,200.00	0.00
210702	Дотоод албан томилолт	161,200.00	161,200.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,048,400.00	1,472,400.00	576,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	608,400.00	608,400.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	864,000.00	576,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,510,900.00	3,510,900.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,510,900.00	3,510,900.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,793,300.00	20,894,270.00	899,030.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,793,300.00	20,894,270.00	899,030.00

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,293,300.00	20,394,270.00	899,030.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	871,230,900.00	800,183,548.28	71,047,351.72
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	665,033,200.00	665,033,200.00	0.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	665,033,200.00	665,033,200.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	206,197,700.00	135,150,348.28	71,047,351.72
320001	Орон нутгийн төсвөөс	206,197,700.00	135,150,348.28	71,047,351.72
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	412.00	412.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	41.00	0.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	329.00	329.00	0.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	329.00	329.00	0.00
630001	Төрийн өмчит ЕБС	329.00	329.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41.00	41.00	0.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	25.00	25.00	
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00	

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,277,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,277,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,277,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,277,100.00
210401	Бичиг хэрэг	176,000.00
210404	Ном, хэвлэл	1,628,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	473,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,277,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	649,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	649,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Сант сумын сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, шилэн дансны нэгдсэн дансны нэгдсэн цахим хуудас болон худалдан авах ажиллагааны цахим төлбөрийн баримтын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Н.Батбаяр хариуцаж хэрэгжүүлэв. Аудитын чанарын анхан шатны хяналтыг “Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар гүйцэтгэв.

Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс Баланс Аудит” ХХК-д хянуулахаар 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сант сумын Ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Суралцагч нэг бүрийн хичээл сурлагын хоцрогдол нөхөх арилгах, тэдний суралцахуйг дэмжих үйл ажиллагааг удирдан зохион байгуулна” гэж тодорхойлж, үйл ажиллагаандаа дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх;
- Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах;
- “Хүүхэдтэй боловсрол” нийгэм сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагаа;
- Ариутгал, халдваргүйтгэлийг сайжруулах
- “Тохижилт, ногоон байгууламж аянг өрнүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”.
- Боловсрол, шинжлэх Ухааны Сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд, Сангийн Сайдын хамтарсан тушаал 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дугаар А/35/А/10/9.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 871,230.9 мянган төгрөгийн 2.0 хувиар буюу 17,424.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,197.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,514.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	48,387.9	74,801.0	26,413.1
Үндсэн хөрөнгө	2,995,299.4	2,919,371.9	(75,927.5)
Нийт хөрөнгө	3,043,687.3	2,994,172.9	-49,514.4
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,043,687.3	2,994,172.9	-49,514.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,043,687.3	2,994,172.9	-49,514.4

Бараа материалын дансны үлдэгдэл 74,801.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 26,413.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 70,748.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 17,791.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, 62,126.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл/ анхны өртгөөр/ 3,406,244.6 мянган төгрөг болж 83,317.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 12,599.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, БСГ-аас 1,547.2 мянган төгрөгийн ном, ДЗОУБ-аас 863.6 мянган төгрөгийн шүүгээ үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусган, сумын ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоолоор 98,327.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,994,172.9 мянган төгрөг болж 49,514.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого 822,662.4 мянган төгрөг болж, өмнөх оны орлогоос 333,256.2 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 373,646.4 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал 862,656.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 57,468.7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь зарим зардлын өсөлтөөс шалтгаалсан байна. Тухайлбал, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 21,899.4 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 21,933.3 мянга, хангамж, бараа материалын зардал 4,913.2 мянга, нормативт зардал 7,334.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 3,519.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 801,915.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс 69,315.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **871,230.9 мянган** төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **871,230.9** мянган төгрөгийн төсөв баталснаас 665,033.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 206,197.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 665,033.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 135,150.3 мянган төгрөгийн нийт 800,183.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 781,007.9 мянган төгрөгийг зарцуулан, 19,175.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **781,007.9** мянган төгрөг буюу 89.6 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлыг 89,323.9 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 899.0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСГ-аас 649.0 мянган төгрөгийн орлого төвлөрснийг бичиг хэргийн зардалд 176.0 мянга, хог хаягдал зайлуулах, ариутгалын зардалд 473.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1.БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын хоёрдугаар хавсралт “*Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 122 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 871,230.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 781,007.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 10.4 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх, бараа материалын үлдэгдэл их хэмжээгээр нөөцлөгдсөн гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт 224,969.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,056.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 222,913.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,056.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой алдааг залруулсан болно.

4.2 Зөвлөмж

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 417.8 мянган төгрөгийг үдийн хоолны зардлаас санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 212,044.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих **22** мэдээллийг хугацаа хоцроосон, 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

4. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал:

4.1 Илрүүлэлт: Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь цалин нэмэгдэл урамшууллын зардлын дүн татварын тайлан дахь цалин хөлсний нийт дүнгээс 10,451.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах” гэсэн заалт болон “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул эхний улиралд багтаан татварын тайлангийн дүнг залруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сант сумын ЕБС	5	224,969.8	1	2,056.0					4	222,913.8